



ХЭНТИЙ АЙМГИЙН
МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 03 сарын 03 өдөр

Дугаар А/57

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх хэсэг, 32.1.3 дахь хэсэг, 32.1.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2026 оны 02 дугаар сарын 25, 2026 оны оны 03 дугаар сарын 02-ны өдрүүдэд орсон цас болон цасан шуурганы улмаас зам, даваа боогдож иргэд малчид зорчих хөдөлгөөн хийх нөхцөл боломжгүй болсон тул Зөөлөн, Өлзийт, Бүрээт, Чандган багуудад цасанд боогдсон зам даваа гүвээг чөлөөлж зорчих хөдөлгөөнийг нээх үйл ажиллагааны шатахууны зардалд 548 000 (таван зуун дөчин найман мянган) төгрөгийг зарцуулсугай.
2. Дээрх зардлыг Гамшгийн эрсдэлийн сангийн зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Б.Нандин-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.
3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Намжилноров)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Н.ХАТАНАБААТАР